



2016 он 01 сар 19 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Санхүүжилт хийхийг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2.7.15 дахь заалтыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Говь ХК нь мөнгөн урсгалын менежментийг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор “Таван Богд Нура” ХХК-д 9,000,000,000 (есөн тэрбум) төгрөгийн санхүүжилт хийхийг Гүйцэтгэх захирал (Б.Амарсайхан)-д зөвшөөрсүгэй. Үүнд:

Санхүүжилтийн дүн	9,000,000,000 (есөн тэрбум) төгрөг
Жилийн хүү	18.5%
Хүү төлөх давтамж	Сар бүр
Хугацаа	24 сар
Зарцуулалт	Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт

2. Санхүүжилт хийхтэй холбоотой гэрээ, хэлцэл болон бусад холбогдох баримт бичигт гарын үсэг зурж баталгаажуулах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Амарсайхан)-д олгосугай.
3. Дээрх хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тул Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэн баталсугай.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД: ЛӨН



Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Д.ХҮРЭЛБААТАР